



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 6/05

Чингис хот

Т.Бямбадуламыг ажилд түр орлон  
гүйцэтгэгчээр томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 26 дугаар зүйлийн 26.1, 2007 оны "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 354 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралт, 2014 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" 332 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Т.Бямбадуламыг 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгчийн үүрийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Т.Бямбадуламын үндсэн цалинг ТҮ-5-2 шатлалаар тогтоож 450224 /дөрвөн зуун тавин мянга хоёр зуун хорин дөрөв/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д зөвшөөрсүгэй.

3. Байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Т.Бямбадуламд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР